



I-VI/2021


Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 19



Нас гүйцсэн эр хонины үнэ Баянхонгор аймагт хамгийн их буюу 270.3 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 6 дугаар сард ат 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 91.5 мянган төгрөгөөр, хязаалан гуны үнэ 1.2 сая төгрөг болж, өмнөх сараас 60.0 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.0 сая төгрөг болж, өмнөх сараас 31.7 мянган төгрөгөөр өссөн байна. Харин эр хонины үнэ 220.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.3 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 144.7 мянган төгрөг болж, өмнөх сараас 200 төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 1. Нас гүйцсэн малын дундаж үнэ, 2021 оны 6 дугаар сард, мянган төгрөгөөр




Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 6 дугаар сард эр хонь Баянхонгор аймагт хамгийн их буюу 270.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 13.9 мянган төгрөгөөр, Дорнод аймагт хамгийн бага буюу 149.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 6.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 2. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 6 дугаар сард, мянган төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 6 дугаар сард цагаан ноолуурын 1-кг-ын дундаж үнэ Баянхонгор, Увс, Завхан, Говь-Алтай аймагт хамгийн их буюу 115.0 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 60.0 мянган төгрөг байна.

Зураг 2. Цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ, 2021 оны 6 дугаар сард, төгрөгөөр



Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 6 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай шир 6.2 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.5 мянган төгрөгөөр, ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 102.4 мянган төгрөг болж, өмнөх сараас 5.1 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг 3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 6 дугаар сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 6 дугаар сард 25кг хивгийн үнэ Дорнод аймагт хамгийн их буюу 25.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.0 мянган төгрөгөөр, Архангай аймагт хамгийн бага буюу 11.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 500 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр: ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын дарга
Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын
Гэрээт ажилтан Б. Оргил
Утас : (976-51)-261561

